

БАТЛАВ.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Х.ТЭМҮҮЖИН

.....

ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦЭД МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Монгол Улс чөлөөт нийгмийн шинэ тогтолцоонд шилжиж анхны ардчилсан шинэ Үндсэн хуулийг 1992 онд батлан гаргахдаа Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа болгон, Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий Үндсэн Хуулийн шүүхийг Үндсэн хуулийн цэц нэртэй байгуулсан нь дэлхийн ардчилсан олон улсын түгээмэл чиг хандлагад нийцсэн алхам болсон.

Үндсэн хуулийн хяналтын гол зорилго бол төрийн байгууллагын дур зоргын шийдвэрээс иргэний үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах, төрийн бүхий л шатанд Үндсэн хуулийн дэг журмыг хангуулж, хууль дээдлэх ёсыг бэхжүүлэхэд оршиж байдаг бөгөөд дэлхий дахинд Үндсэн хууль ёсны төлөвшилд Үндсэн хуулийн хяналтын байгууллагын үүрэг оролцоо нэн тэргүүнд тавигддаг гэж үздэг.

Монгол Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай 36 зүйлтэй хуулийг 1997 оны 5 дугаар сарын 01-ний өдөр баталж өнгөрсөн хугацаанд 6 удаа нэмэлт, өөрчлөлт оруулаад байна.

Монгол Улсын тухайд өмнө нь Үндсэн хуулийн биелэлтэд хяналт тавьж, Үндсэн хуулийн маргаан шийдвэрлэж ирсэн практик туршлага, энэ талаарх онолын суурь болон харьцуулсан судалгаа хангалттай хийгдэж байгаагүй үед уг хууль батлагдсан. Үүнтэй холбоотой хуулиар зохицуулбал зохих зарим харилцааг зохицуулалтгүй орхигдуулсан болон чиг үүргийн давхардал, хийдэл, Үндсэн хууль хэрэглэх явцад гарсан зөрчил, Үндсэн хуулийн шүүх мөн, биш болох тухай маргаан, үл ойлголцол нь энэ институцийн чиг үүргийг илүү тодорхой, Үндсэн хуулийн шүүх болох тал руу илүү бодитой шийдэл хийх шаардлага үүсгэж байна.

Үндсэн хууль судлаачид энэ хууль нь Үндсэн хуулийн хяналтыг бүрэн утгаар хэрэгжүүлэх боломжийг хязгаарлаж байна гэж шүүмжилж ирсэн бөгөөд уг шүүмж сүүлийн жилүүдэд хуульч, эрдэмтэн судлаачдын дунд улам бүр тод илэрхийлэгдэж, академик хүрээнд нэгдсэн байр суурьтай болох хандлага давамгайлах боллоо. Үндсэн хуулийн цэцийн тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох, Цэцийн хараат бус, бие даасан, мэргэшсэн байдлыг бэхжүүлэх, Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох процессыг ил тод, нээлттэй, олон талын оролцоотой болгох, иргэний үндсэн эрхийн бодитой хамгаалалтыг бий болгон үндсэн эрхийн маргааныг Үндсэн хуулийн цэц хянан

шийдвэрлэдэг болгох, процессын тодорхой, шударга байдлыг дээшлүүлэх нь зүйтэй талаар олон эрх зүйн баримт бичиг, хөтөлбөрүүдэд тусгаж ирсэн.

Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийг дэлхийн бусад улсын Үндсэн хуулийн шүүхийн нийтлэг жишигт ойртуулах, үндсэн хуулийн эрх зүйн маргааныг Үндсэн хуулийнхаа үзэл баримтлалд нийцүүлэн онолын түвшинд, хараат бус, шударга, бодитой шийдвэрлэх эрх зүйн орчин, баталгааг бүрдүүлэх үүднээс Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийг шинэчлэн найруулах шаардлагатай гэж үзлээ.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн Засаглалын бодлого бүлгийн "Хараат бус, бие даасан шүүх, хүний эрхийг дээдэлсэн эрх зүйн шинэтгэл" хэсгийн 4.4.2 дахь заалтад "Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн хараат бус, бие даасан, ил тод байдлыг хангаж, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож Үндсэн хуульд ёс, хууль дээдлэх ёс, хүний эрхийг хангах тогтолцоог боловсронгуй болгоно" гэж, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-ийн 84, 85-д Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай /Шинэчилсэн найруулга/, хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр заасан.

Мөн Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.1.1 дэх хэсэгт "Иргэний үндсэн эрхийн маргааныг шийдвэрлэх, эрх мэдэл хуваарилалтын хяналт, тэнцлийг хангуулах чиглэлээр Үндсэн хуулийн цэцийн бүрэн эрхийг тодотгоно" гэж заасан төдийгүй Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 11 сарын 15-ны өдөр баталсан "Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөө"-ний стратегийн зорилго 1-д "Монгол Улсын Их Хурал хүн төвт, хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн үзэл санааг төгөлдөржүүлнэ" гэж заасан бий.

Хуулийн төслийг боловсруулахдаа Үндсэн хуулийн цэц иргэний үндсэн эрхийн баталгаа болж иргэдийн өргөдлөөр Үндсэн эрхийн маргааныг хянан шийдвэрлэх бүрэн эрхийг хэрэгжүүлэх, түүнчлэн өргөдөлд тавих шалгуурыг нарийвчлан тусгах, Үндсэн хуулийн хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх үүднээс Улсын Их Хуралд тодорхой асуудлаар цөөнх болсон гишүүд Үндсэн хуулийн цэцэд хандаж, хууль, бусад шийдвэр Үндсэн хуульд нийцээгүй, түүнчлэн эрх бүхий албан тушаалтан Үндсэн хууль зөрчсөн буюу түүнийг огцруулах, эгүүлэн татах үндэслэлтэй гэж үзвэл хүсэлт гаргаж болох болон Цэцэд маргаан хянан шийдвэрлэх, маргаантай асуудлыг хянан үзэхтэй холбоотой харилцааг нарийвчлан зохицууллаа.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн гол өөрчлөлт Үндсэн хуулийн цэц үндсэн эрхийн маргааныг иргэдийн өргөдлийн дагуу өөрийн санаачилгаар буюу эрх бүхий байгууллага, албан тушаалтны хүсэлтээр мөн эрх мэдэл хуваарилалтын маргааныг Үндсэн хуульд заасан эрх

мэдэл хуваарилалтын оролцогчдын хүсэлтээр хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахаар боловсрууллаа.

Нэгдүгээр бүлэгт, нийтлэг үндэслэлийн талаар буюу хуулийн зорилго, нэр томъёоны тодорхойлолт, маргаан хянан шийдвэрлэх хүрээ, маргаан хянан шийдвэрлэх хугацаа, тоолох зохицуулалт, маргаан хянан шийдвэрлэхтэй холбогдон гарах зардлыг хэрхэн шийдвэрлэх талаар тусгалаа.

Хоёрдугаар бүлэгт, Маргаан хянан шийдвэрлэх зарчмын талаар буюу хараат бус байх, хамтын, ил тод байх, тэгш эрхийг хангах, цэц өөрөө нотлох, маргаан хянан шийдвэрлэх хэл, бичиг, хуралдааныг биечлэн, тасралтгүй явуулах талаар тусгасан.

Гуравдугаар бүлэгт, цэцэд хандах хэлбэр, хугацаа, өргөдөл, мэдээлэл, хүсэлтэд тавих шаардлага, хүлээн авах зохицуулалт, цахим бүртгэлийн талаарх зохицуулалтыг тусгалаа.

Дөрөвдүгээр бүлэгт, маргааны оролцогчийн эрх зүйн байдлын талаар буюу маргааны оролцогч, үндсэн оролцогчийн эрх, үүрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлөх, өмгөөлөгч, гэрч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, хуралдааны нарийн бичгийн даргын эрх зүйн байдлын талаар тусгалаа.

Тавдугаар бүлэгт, маргаан хянан шийдвэрлэх нийтлэг журмын талаар буюу маргаан хянан шийдвэрлэх үндэслэл, өргөдөл, мэдээлэл, хүсэлт маргааныг хуваарилах болон холбогдох бусад журам, хянан шийдвэрлэхэд бусад байгууллага дэмжлэг үзүүлэх, цэцийн даалгаврыг биелүүлэх, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх зохицуулалт, маргааныг хэрэгсэхгүй болгох, аман хуралдааны тэмдэглэлийн талаар тусгалаа.

Зургадугаар бүлэгт, маргаан хянан шийдвэрлэх зохион байгуулалт, хуралдааны хэлбэр, бага, дунд, их суудлын нарийвчилсан зохицуулалт болон маргааныг хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, аман хуралдааны дараалал, хуралдаанд хүрэлцэн ирээгүйн үр дагавар, зөвлөлдөх хуралдаан, цэцийн дүгнэлтийг Улсын Их Хуралд оруулах болон маргааныг эцэслэн шийдвэрлэх зохицуулалтыг тусгалаа.

Долдугаар бүлэгт, цэцийн шийдвэр гаргах, түүнийг мэдээлэх талаар буюу маргааныг зөвлөлдөх хурлаар хэлэлцэх, цэцийн шийдвэрийн үндэслэлийг хэлэлцэн тогтоох, цэцийн шийдвэрийн бүтэц, цэцийн шийдвэрийг биелүүлэх, нийтлэх журам, цэцийн шийдвэрийн үр дагаврын талаар болон түр түдгэлзүүлэх зохицуулалтын талаар тусгалаа.

Наймдугаар бүлэгт, тусгай журмын зохицуулалт буюу хууль, бусад шийдвэрт холбогдох маргаантай асуудал, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр үүссэн маргаантай асуудал, албан тушаалтанд холбогдох маргаантай асуудал, үндсэн эрхийн маргаан, сонгох сонгогдох үндсэн эрхийн маргаан, эрх мэдэл хуваарилалт хоорондын маргаан, ард нийтийн санал асуулга, сонгуульд холбогдох маргаантай асуудлын талаарх тусгай журмын зохицуулалтыг тусгалаа.

Есдүгээр бүлэгт, бусад зохицуулалтын талаар буюу хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох зохицуулалтыг тусгасан болно.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн төсөл батлагдсанаар дараах зарчмын шинэлэг зохицуулалт орж, холбогдох эрх зүй, эдийн засаг, нийгэм соёлын үр дагавар үүснэ гэж үзэж байна. Үүнд:

Үндсэн хуулийн Жаран дөрөв, Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны хүрээнд "Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих", Үндсэн хууль зөрчсөн маргааныг хянан шийдвэрлэх чиг үүргээ Цэц нь иргэнээс ирүүлсэн "үндсэн эрх" зөрчигдсөн тухай өргөдлийг хүлээн авч шийдвэрлэх зохицуулалтыг тусгалаа. Ингэснээр Үндсэн хуульд заасан иргэний үндсэн эрхийг тодорхой тохиолдолд хэрэглэж Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалд заасан хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийн баталгааг дээшлүүлэх нөхцөл бүрдэнэ.

Үндсэн хуулийн процессын эрх зүйн дэлхий нийтийн чиг хандлагын хүрээнд "өргөдөлд" тавигддаг шалгуурыг нарийвчлан тусгалаа. Тухайлбал, иргэн Цэцэд хандахын өмнө эрх сэргээх, хамгаалах шүүхийн болон бусад арга замыг гүйцээсэн байх нарийвчилсан шаардлагыг тогтоосон нь Үндсэн хуулийн цэцэд хүн бүр хандах зохиомол ачааллаас хамгаалах үр дүнтэй төдийгүй, Үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлэх боломжийг нээж, бусад улсын нийтлэг хандлагатай уялдсан зохицуулалт болно.

Цэц нь Үндсэн хуулийн шүүх болохын хувьд хянан шийдвэрлэх маргааны агуулгыг "хамаарлын зарчмын" хүрээнд томъёоллоо. Ингэснээр өргөдөл, хүсэлтийн шаардлага, хүрээ хязгаарыг тодорхой тогтоож, өөрийн чиг үүрэгт үл хамаарах асуудлаар Цэцэд хандах боломжгүй байхаар зохицууллаа.

Одоо мөрдөж буй хууль тогтоомжийн дагуу Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай асуудлаар Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах эрхтэй хэдий ч түүхэндээ өнгөрсөн жил нэг л удаа хандсан байна. Иймд ардчилсан зарчмыг хангах, Үндсэн хуулийн хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх үүднээс Улсын Их Хурлын тодорхой тооны гишүүн Үндсэн хуулийн цэцэд хандаж, хууль, бусад шийдвэр Үндсэн хуульд нийцсэн эсэх, түүнчлэн эрх бүхий албан тушаалтан Үндсэн хууль зөрчсөн буюу түүнийг огцруулах, эгүүлэн татах Үндсэн хуулийн үндэслэлтэй эсэх маргаантай асуудлаар хүсэлт гаргаж болохоор тусгав. Ингэснээр Үндсэн хуулийн хяналтыг Улсын Их Хурлын гишүүд дэмжин хэрэгжүүлэх нөхцөл бүрэн утгаараа бүрдэхийн сацуу Үндсэн хуульд заасан ардчилсан ёс, хууль дээдлэх ёс харилцан тэнцвэртэй хэрэгжих нөхцөл бүрдэнэ.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн дагуу Цэцэд хандаж өргөдөл, мэдээлэл, хүсэлт гаргахад тухайн эрх зүйн акттай холбоотой тодорхой хугацаа заагаагүй бөгөөд энэ нь тодорхой сөрөг үр дагаврыг дагуулж байгаа тул хууль тогтоомжоос бусад шийдвэр гарсан өдрөөс хойш нэг жилийн дотор, сонгуулийн төв байгууллагын шийдвэр гарсан өдрөөс хойш хоёр сарын дотор, шүүхийн

шийдвэр эсхүл эрх зүйн бусад актыг гардан авснаас хойш 30 хоногийн дотор Үндсэн эрхийг нь зөрчсөн гэж үзэж байгаа иргэн өргөдөл гаргахаар зохицууллаа.

Түүнчлэн Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан албан тушаалтан Үндсэн хууль зөрчсөн шийдвэр, үйлдэл, эс үйлдэхүй гаргаснаас хойш нэг жилийн дотор, огцруулах, эгүүлэн татах асуудлаар тухайн албан тушаалтны бүрэн эрхийн хугацаанд хүсэлт гаргах, хууль тогтоомж Үндсэн хуульд нийцсэн эсэх маргаантай асуудлаар хэдийд ч, харин бусад маргаантай асуудлаар хүсэлт гаргах үндэслэл бий болсон өдрөөс хойш нэг жилийн хугацаанд хүсэлт гаргаж болохоор зохицууллаа.

Үндсэн хуулийн цэцэд ирсэн аливаа өргөдөл, мэдээллийн талаарх урьдчилсан хяналтыг Үндсэн хуулийн шүүхийн тамгын газар, Ерөнхий бүртгэлийн хүрээнд гүйцэтгэдэг жишиг бусад улс оронд тогтсон бөгөөд энэ нь Цэцэд ирсэн өргөдөл, мэдээллийн анхны буюу хэлбэрийн шалгалтыг Тамгын газар, Ерөнхий бүртгэлийн хүрээнд шалгаж, хуулийн шаардлага хангаагүй асуудалд бүртгэгч /хуульч/ нар хариу өгч буцаах, зарим тохиолдолд хуулийн шаардлага хангуулах арга хэмжээг авахаар журамлах нь Үндсэн хуулийн цэцийн гишүүдэд зохиомол ачаалал үүсэхээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой тул хуулийн төсөлд тусгалаа.

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуульд зааснаар өргөдөл, мэдээллийг урьдчилан шалгах хугацааг 14 хоног байхаар заасан бөгөөд хугацааг сунгах талаарх тодорхой зохицуулалт байхгүй, харин Цэцийн хуралдаанд бэлтгэх хугацаа 30 хоног байхаар заасан нь маргааныг бүрэн гүйцэт, бодитой, онолын түвшинд шийдвэрлэхэд оновчтой бус, хэт богино хугацаа юм. Иймд, Ерөнхий бүртгэгч нь өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг Цэцэд ирүүлснээс хойш 30 хоногийн дотор шаардлагыг хангасан эсэх зэргийг нягтлан үзэж, бүртгэх эсэхийг шийдвэрлэх, түүнчлэн бүтгэхээс татгалзсан хариуг маргагч тал эс зөвшөрвөл 30 хоногийн дотор Цэцэд дахин хандаж болох, энэ тохиолдолд уул өргөдөл, хүсэлтийг ажлын таван өдрийн дотор Бага суудлын бүрэлдэхүүнд гардуулж бүртгэхээр зохицууллаа. Цэц маргааныг үүсгэснээс хойш 90 хоногийн дотор хянан шийдвэрлэх бөгөөд тухайн маргаан ээдрээ, төвөгтэй бол энэ хугацааг 90 хоногоор хоёр хүртэл удаа сунгаж болохоор тусгаснаар бусад улсын жишигт нийцэхийн сацуу маргааныг мэдээлэл, судалгаа, тооцоололд үндэслэн тодорхой цаг хугацааны дотор шийдвэрлэх ач холбогдолтой.

Шүүхийн нийтлэг жишгийн дагуу болон Цэцийн гишүүний хараат бус, эрх тэгш байдлыг хангах, Үндсэн хуульд заасан зохицуулалтад нийцүүлж Цэцэд ирсэн өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг илтгэгч гишүүнд хуваарилах болон Цэцийн хуралдааны бүрэлдэхүүнийг томилохдоо Цэцийн гишүүдийн зөвлөгөөнөөр тухайн жилд тогтоосон хуваарь, журмыг баримтлахаар тусгав.

Бусад улсын туршлагыг судлан үзэхэд ихэнх тохиолдолд маргаан үүсгэх эсэх асуудлыг 3-5 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэдэг бөгөөд санал нэгтэй татгалзсанаас бусад тохиолдолд маргаан үүссэнд тооцдог зохицуулалт нийтлэг байна. Иймд өргөдөлийг нэг гишүүн урьдчилан шалгаж маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх эсэх асуудлыг дангаараа шийдвэрлэж байгаа одоогийн зохицуулалтыг өөрчлөн 3 гишүүний бүрэлдэхүүнтэй Бага суудал

маргаан үүсгэх эсэхийг олонхоороо шийдвэрлэдэг болсноор Үндсэн хуулийн хяналтад тодорхой үр дүн гарна гэж үзэж байна.

Үндсэн эрхийн маргааны нэг тал нь иргэн, нөгөө тал нь төрийн байгууллага, албан тушаалтан байдаг тул нотлох баримтыг гаргах, бүрдүүлэхэд учирч болох саад бэрхшээлийг арилгах үүднээс нотлох баримттай холбоотой зохицуулалтыг илүү тодорхой болгох, "шүүх нотлох зарчим"-ын агуулгыг Цэцийн онцлогт нийцүүлэн томъёолсноор иргэдэд үүсдэг хүндрэл, бэрхшээлийг шийдвэрлэнэ.

Маргаан хянан шийдвэрлэхтэй холбоотой зохицуулалтыг нарийвчлан зохицуулах, түүнчлэн Цэцийн хяналтын онцлогтой уялдуулан Цэцийн хуралдааныг бичгэн хэлбэрээр зонхилон явуулах, онцгой тохиолдолд болон хүсэлтийг шийдвэрлэх Цэцийн хуралдааныг зөвлөлдөх хэлбэрээр явуулдаг болсноор онолын шүүх болох нөхцөл хангагдана гэж үзэж байна.

Цэц дүгнэлтээ ёсчилсноос хойш 24 цагийн дотор Улсын Их Хуралд хүргүүлэх, богино хугацаанд тогтоолоо бичиж эцэслэх шаардлага тавигддаг нь Цэцийн шийдвэрт үндэслэл дэлгэрэнгүй бичих боломжийг хязгаарладаг. Иймд Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн үндэслэлийг онолын түвшинд, ойлгомжтой, үндэслэл сайтай гаргах, үндэслэлээ бичгээр дэлгэрэнгүй тайлбарлах шаардлагын үүднээс хуралдаан дууссанаас хойш хоёр сарын дотор Цэцийн шийдвэрийг эцэслэн бичиж, ёсчлох, улмаар тодорхой хугацаанд нийтэд мэдээлэх, нийтлэх, эмхэтгэж хэвлэхээр хуульчлав.

Мөн маргааны оролцогчдын эрх зүйн байдлыг тодорхой болгох, эрх үүргийг тусгайлан хуульчлах, Үндсэн хуулийн цэцийг үл хүндэтгэсэн, хуралдааны дэг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг тусгав.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаарх санал

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.